

“АЛТАН ХАРААЦАЙ”-Н ҮҮРЭН ДЭХ АЛТ ЭРДЭНЭСИЙГ НЭЭХҮЙ

Г. Галбаяр *

Мөнх хөх тэнгэрийн доорх мянга мянган он жилд хүмүүний үр сад эрдэм хэмээх гайхамшигийг сурахаар ертөнцийн хязгаараар өчүүхэн ч чөлөө завгүй зорчсоор байдаг нь хорвоогийн хүн зоны зам мөр, хувь тавилан ижлийн гэрч гэгээ буй за.

Тэртээх 1975 оны XI сарын 13-ны Пүрэв гарагийн үдээс хойшхон Улаанбаатар хотын төмөр замын буудалд Бээжин-Москвагийн чиглэлийн олон улсын галт тэрэг ирж зогсоход “*хорин настай, хонгор зүстэй*” харь орны нэгэн залуу дотоод сэтгэлдээ битүүхэн түгшүүр тээх ч чинад алсын бодолдоо их зорилго өвөртөлж, монголын газар нутаг дээр хөл тавив. Энэ бол бидний өвөг дээдсийн мянган он, түмэн жилийн чинадад бүтээн хөгжүүлж ирсэн “*өсөхөөс сурсан үндэсний хэл, мартаж болошгүй соёл*”-оос Япон улсын иргэн Казүюки Окада суралцахаар яваа нь байжээ.

Тэрхүү дурсгалт мөчөөс хойш дөчөөд жил урсан өнгөрч 2014 онд Японы Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн профессор, нэрт монголч эрдэмтэн К. Окада багшийн монголын орчин үеийн уран зохиол судлалын чиглэлээр бичсэн өгүүллүүдийн түүвэр Улаанбаатар хотноо “АДМОН ПРИНТ” ХХК-ны хэвлэх үйлдвэрт хэвлэгджээ. Эрдэм судлалын ном гэхэд уран сайхантай нэрлэж дээ гэж бодогдмоор “Алтан хараацай” гэсэн нэртэй ажээ. Гэвч түүнд тодорхой учир шалтгаан бий болой. Профессор К. Окада номынхоо өмнөх үгэнд “*Япон, Монгол хоёр улс 1972 оны II сард дипломат харилцаа тогтоож, 2 жилийн дараа буюу 1974 оны IX сард Соёлын солилцооны тохиролцоог тогтоосны үр дүнд хоёр улсын хооронд оюутан, багш нарын солилцоо анх эхэлсэн юм. Миний бие тус тохиролцооны дагуу БНМАУ-ын Засгийн газрын тэтгэлэгт гадаад оюутнаар томилогдож Японоос түүчээлэн ирсэн анхны япон оюутан байлаа. Тийм учраас сургуулийн багш нар маань “Чи ёстой “Алтан хараацай” юм аа”, “Чамд “Ууганбаяр” гэсэн монгол нэр өгье” хэмээн дандаа ярьдаг байж билээ. ... Одоо ийнхүү уншигч Та бүхэнд толилуулж байгаа Монголын орчин үеийн уран зохиол судлалын монгол хэлээрх өгүүллийн “Алтан хараацай” хэмээх түүвэр бол Монгол улсад анх хөл тавьсан цагаас хойш 40 шахам жил болж буй энэ 2014 онд миний 60 насны ойд зориулан нийтлүүлж байгаа ном билээ*” (5-7 дугаар тал) хэмээн өгүүлжээ. Энэхүү тайлбар нь уг номын нэрийн тайлал төдийгүй Монгол, Япон хоёр улсын шинэ цагийн соёлын харилцаа, монголын судлал тэр дундаа монголын орчин үеийн уран зохиол судлалын түүхэн чухал баримт болох бүтээл болсныг гэрчилнэ. Уул номын зохиогч К. Окада нь МУИС-д монгол хэл, уран зохиол, соёлын чиглэлээр чамгүй ихийг сурч,

* МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхим

цаашид судлан шинжлэх судалгааны чиглэл, сэдвээ олоод эх орондоо эргэн харьж төрөлх Токиогийн Гадаад Судлалын Их Сургуулийн профессор К. Сакамото, профессор Ш. Озава, профессор Х. Хасүми зэрэг монголын судлалын нэрт эрдэмтдэд шавилан, монгол хэл, уран зохиол, соёл, түүхийг үе үеийн япон залууст заан сургаж багшлахын зэрэгцээ Монголын орчин үеийн уран зохиолыг судлан шинжилж, Монгол-Японы соёлын гүүр болон өдгөө хүртэл ажиллаж байгаа ажээ.

“Алтан хараацай” номд 17 эрдэм шинжилгээний өгүүлэл, номын 2 шүүмжийн өгүүлэл, 9 ярилцлага, зохиогчийн Монголын зохиолчдын байгууллагын 80 жилийн ойд илгээсэн баярын цахилгаан багтжээ. Зохиогчийн намтар бүтээлийг тодруулсан бүтээлийн жагсаалт, гэрэл зургууд, Өвөрмонголын Багшийн Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн профессор Ц. Цолмон гуайн бичсэн “Монголын орчин үеийн уран зохиол судлагч, монголч эрдэмтэн Окада Казүюки” гэсэн хөрөг өгүүллийг уг ном хэвлүүлсэн нь чухал ач холбогдолтой болсон байна.

“Алтан хараацай” номын үндсэн хэсэг болох 17 өгүүллийг сэдвийн хувьд багцалж үзвэл доорх хэдэн хэсэгт хамаарагдана.

1. Д. Нацагдорж судлал. Үүнд, “Some Remarks on the Textual Study of the Short Story “White Month and Black Tears” by D. Natsagdorj”, “Д. Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийн дүрийн асуудалд”, “Д. Нацагдоржийн шоронд байхдаа 1932 онд бичсэн мөчлөг шүлгүүдийн тухай”, “Д. Нацагдорж ба “Миний нутаг” шүлэг”, “Д. Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг ба “Түүхийн шүлэг”, “Г. Жигжидсүрэнгийн найруулсан “Их Нацагдорж” баримтат-уран сайхны киноны тухай”

2. Ц. Дамдинсүрэн судлал. Үүнд, “Цэндийн Дамдинсүрэн ба “Сэхээтний төөрөгдөл” гэгчийн тухайд”, “Цэндийн Дамдинсүрэн ба социалист модернизаци” (“Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл” өгүүллэгийн жишээн дээр), “Ц. Дамдинсүрэнгийн таталган бичсэн нэгэн зурвасын тухай”

3. Монгол, Японы нийгэм ба уран зохиолын харилцаа холбоо. Үүнд, “Буг чөтгөр дахин сэргэнэ гэж үү?” (Монголын нэгэн эрдэмтний өгүүллийн тухайд), “Доктор Ш. Озава Монголын орчин үеийн уран зохиолын тухай”, “Монгол романд дүрслэгдсэн Японы олзлогдогсод”, “Япон улс дахь Монголын орчин үеийн уран зохиолын судлалын тухай”, “Хар сүүдрээс гийсэн гэрэл гэгээ” (“Сүүдэр” уран сайхны киноны тухай), “Монголын орчин үеийн уран зохиол ба дайн байлдаан”

4. Бусад. Үүнд, “Эсэргүү” яруу найрагч Рэнчиний Чойном”, “Монголын орчин үеийн уран зохиолыг үечлэлийн асуудалд” (Монгол улс ба Өвөр Монголын жишээн дээр)

Дээрх агуулгын ангилал профессор К. Окада багшийн монголын орчин үеийн уран зохиолын нарийвчилсан судалгааны чиглэлийг нь тодорхой харуулж байна. Өөрөөр хэлбэл монголын орчин үеийн уран зохиол хэмээх далайд хөвсөн бус өөрийн сонирхсон хэсгийг сонгож тодорхой болгон түүнийгээ нарийвчлан судалдаг болохыг гэрчилнэ.

Нэг. Д. Нацагдорж судлалаар олон өгүүлэл бичжээ. Энэ ч утгаар нь түүнийг “Д. Нацагдорж судлаач” хэмээн тодотгож заншжээ. “Япон дахь “Д. Нацагдорж судлал”-ыг эдүгээ түүчээлэн манлайлж буй эрдэмтэн бол профессор Окада Казүюки [Okada Kazuyuki] багш мөн билээ” (9 дүгээр тал) гэсэн хянан найруулагчийн тодорхойлолт, бүтээлийн жагсаалт зэрэг нь түүнийг “Д. Нацагдорж судлаач” гэдгийг баттай гэрчилнэ. Д. Нацагдорж судлалаар хэд хэдэн өгүүлэл бичиж, олон улсын хуралд хэлэлцүүлсний төлөөлөл болгож уг номонд хэвлэгдсэн “Д. Нацагдорж ба “Миний нутаг” шүлэг” өгүүллийнх нь тухай задалж үзье.

“Д. Нацагдорж ба “Миний нутаг” шүлэг” өгүүлэлдээ нэгд, “Д. Нацагдорж “Миний нутаг” шүлгээ хэзээнээс зохиож, бичиж эхэлсэн бэ? Тэгээд энэ шүлэг ямархуу явцаар 1934 оны “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүлийн анхны дугаарт нийтлэгдэх болсон бэ?” (81дүгээр тал), хоёрт, Д. Нацагдорж энэ шүлгээ ямар учир шалтгаанаас болж, ямар утга агуулгатайгаар бичсэнийг судлан шинжилсэн байна. Юуны өмнө Д. Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг хэдийд зохиогдсоныг судлан шинжилсэн Б. Содном, Ц. Дамдинсүрэн, Д. Цэдэв нарын зэрэг Д. Нацагдорж судлаачдын энэ сэдвээр судласан судалгаа хийгээд Д. Цэдэндамба, Я. Цэвэл зэрэг тухайн цагийн ахмад нөхдийн дурдатгал яриа, санал бодлыг шүүрдэн авч үзээд “Миний нутаг” шүлгийн зохиогдсон оны тухай зөрөөтэй үзэл баримтлал, судалгаа шинжилгээг тодруулаад тэр бүхнийг тухайн нийгмийн хөгжил хувьсал, цаг үеийн үйл хэргүүдтэй нь уялдуулан дээр өгүүлэгдсэн дурсамж дуртадгал, судалгаа шинжилгээний баримтуудыг дахин нэгтгэж хоорондын зөрөөтэй үзэл санааны учир холбогдлыг нарийн судлаад “Д. Нацагдорж “Миний нутаг” шүлгээ 1931 онд бичиж эхлээд, мөн оны VII сарын 11-нд Ардын хувьсгалын 10 жилийн ойд зориулж Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн ханын сонинд эхний хэсгийг анх нийтлүүлж, 1932 оны өвөл МАРЗ-ын нэг хуралд хэлэлцүүлсний дараа бүрэн бичиж дуусгасан гэж хэлж болох юм” (83 дугаар тал) гэсэн дүгнэлтэд хүрчээ. Мөн уг шүлэг тэр үедээ хэвлэгдэлгүй 1934 оны “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүлийн анхны дугаарт анх удаа бүрэн эхээрээ хэвлэгдсэний учрыг тодруулсан байна. Судлаач Б. Содномын “1930 оноос эхлэн зүүний нугалаатан нарт хавчигдаж байсан тэр үедээ Нацагдорж уг шүлгийн сэдвийг олж аваад, заавал бичих шаардлагатай болжээ”¹ гэж бичсэнээс ургуулан зүүний нугалаатан гэгчүүд хуучны бүх зүйлийг үгүйсгэн буруутгах болсныг эсэргүүцэн монгол орныхоо сайн сайхан бүхнийг магтан уран сайхнаар бичсэн нь уг шүлгийн бичигдэх болсон шууд шалтгаан, утга агуулгын хослолыг харуулж байна.

“Миний нутаг” шүлэгт зүүний нугалааг шууд шүүмжилсэн уг хэллэг нэг ч алга байна. Харин шүлгийн сүүлчийн XII бадагт хүрвэл Д. Нацагдоржийн уг зохиолыг бичсэн жинхэнэ учир шалтгаан, гол санаа зорилго нь тодорхой мэдрэгдэх болно.

Өссөн төрсөн бидний үндэсний хайртай нутаг

Өнгөлзөгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөөнө

Хувьтай энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж

Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяа байгуулья

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

“Дайсан” гэж чухамдаа “Япон”-ыг хэлж байна. Тэр үед Манжуур, зүүн Монгол, өвөр Монголд эзэрхэг түрэмгий бодлогыг явуулж байсан Япон улс, БНМАУ (Бүгд Найрамдах Монгол Ард Улс)-ыг түрэмгийлэх завшааныг сэмхэн хайж байлаа. Иймэрхүү олон улсын тулгамдсан ноцтой байдалд Д. Нацагдорж Монголын ард түмэнд хандаж Японы аюул заналд шантрахгүй, хайрт эх орноо шийдвэртэй хамгаалж, ардын хувьсгалыг гүнзгийрүүлье хэмээн уриалжээ. Зүүний нугалааны хор уршгаас илүү хор уршигтай Японы түрэмгийллийн аюул заналаас Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолоо баттай хамгаалах явдал бол Д. Нацагдоржийн “Миний нутаг” шүлэгтээ илэрхийлэх гэсэн гол санаа мөн байна” (84-85 дугаар тал) гэсэн нэн сонирхолтой “шударга” дүгнэлтэд хүрсэн байна. Бараг нэг ч монгол хүн уг шүлгийн

¹Содном Б. Дашдоржийн Нацагдоржийн намтар зохиол. Уб., 1966. 95-96 дугаар тал

“өнгөлзөгч дайсан” гэдгийг шууд утгаар нь энэ бол Япон хэмээн ойлгож байгаагүй байх. Гэтэл үүнийг тухайн цаг үеийн нөхцөл байдалтай нь уялдуулан өнөөдөр япон судлаач “Энэ дайсан гэгч нь “Япон” шүү” гэж өгүүлсэн нь нэгд, тухайн судлаачийн гярхай ажиглалтыг, хоёрт, судлаачийн аливаа зүйлд үнэнээр нь шинжлэх ухааны үүднээс хандаж чаддагийг, гуравт, “япон” гэдгийг хашилтанд хийсэн нь монгол хэл, найруулгад хашилтын үүрэг учир холбогдолтой уялдуулан авч үзвэл “тэр дайсан бол бүх япон хүмүүс биш” гэсэн санааг тодорхой илэрхийлсэн хэрэг. Үнэндээ ч дайн дажин гэгчийг эгэл жирийн иргэн хүн өдөөдөггүй билээ.

“Д. Нацагдорж ба “Миний нутаг” шүлэг” өгүүллээс авч үзвэл К. Окада профессор аливаа зүйлийг нарийн гярхай ажиглаж, түүнийгээ судалгааны эргэлтэнд гарцаа байхгүй тодорхой байх хувилбараар татан оролцуулж, логик гаргалгааны үүднээс нэгээс нөгөөг зөв ургуулан нягт нямбай судлан шинжилдэг өвөрмөц туршлагатайг харуулж байна. Энэ нь япон хүний аливаа зүйлд ул суурьтай, нягт нямбай ханддагтай холбоотойн зэрэгцээ авьяас билигтэй, судалгаа шинжилгээний ажилдаа дур сонирхолтойг гэрчилж байгаа хэрэг.

Хоёр. Ц. Дамдинсүрэн судлалаар цөөнгүй өгүүлэл энэ номонд хэвлэгдсэн ч “Ц. Дамдинсүрэн ба социалист модернизаци” (“Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл” өгүүллэгийн жишээн дээр) өгүүлэл нь хэн хүний сонирхолыг татна. Тус өгүүлэлдээ зохиолч Ц. Дамдинсүрэн гуайн ёс сургахууны сэдэвтэй гэж хэлж болохоор “Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл” өгүүллэгийг зохиолын үйл явдалд хөтлөгдөх ч дүрүүдийн хэл яриа, үйл хэрэг, үзэл бодлын дагуу сонирхолтой задлан шинжлээд өгүүллэг бичигдэх үеийн монголын нийгмийн амьдралд гарч байсан өөрчлөлт шинэчлэл, зарим түүхэн бодит хүний үйл хэргийн замнал зэрэгтэй судалгааны явцаа улируулан зохиомжлон авч үзээд “Ц. Дамдинсүрэн “Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл” өгүүллэгийн гол зорилт нь монголын уламжлалт соёл буюу нүүдлийн соёлыг хайрлан хамгаалж, дахин үнэлэх, социалист модернизаци буюу зөвлөлтжүүлэх явдлыг далд шүүмжлэхэд оршиж байна. Тэгээд ийм зорилтыг урнаар өнгөлөн далдлахаар социалист модернизацийн бэлгэ тэмдэг болсон радио хүлээн авагч мэтийн янз бүрийн “жижиг хэрэгсэл”-ийг ашигласан байна” (128 дугаар тал) гэж далд утгыг нь нээн өгүүлжээ. Энэ өгүүллийн үргэлжлэл гэж хэлж болохоор “Ц. Дамдинсүрэнгийн таталган бичсэн нэгэн зурвасын тухай” гэсэн түүхийн зурвас үнэн, хүний мөн чанарын тухай өгүүлсэн сонирхолтой өгүүлэл ч уг түүвэртээ хэвлүүлсэн байна. Уншигч Та энэ хоёр өгүүллийг нэгээс нөгөөг нь ургуулан харилцан холбоо хамааралд нь уншаад судлаачийн авьяас билигийг мэдрэх төдийгүй нэгийг бодож, хоёрыг ухаарах нь гарцаагүй. Профессор К. Окада энгийн мэт зүйлийг эгэл бус шинжээс нь сонгон авч энгийн бус зүйл болохыг нь нягт нямбай судлан гаргаж тавихдаа асуудалд шинжлэх ухаанч, зарчимч, ноён нуруутай ханддаг болох нь харагдана. Энэ нь судлаачийн тууштай зарчимч зан чанарын зэрэгцээ судалгаа шинжилгээний өвөрмөц арга зүйг нь давхар илэрхийлж байна. Энэ нь тэрбээр өдгөө нэгэнт өөрийн гэсэн судалгаа шинжилгээний дэгийг үүсгэж чадсаны гэрч.

Гурав. Монгол, Японы нийгэм болоод урлаг уран зохиолын харилцаа холбооны асуудлаар цөөнгүй өгүүлэл энэ номд хэвлэгдсэн ч “Хар сүүдрээс гийсэн гэрэл гэгээ” (“Сүүдэр” уран сайхны киноны тухай) өгүүлэл нь олон зүйлийг төлөөлж чадах ч бас судлаачийн билиг авьяасыг нэлээд талаас нь гэрчилж чадаж байна. “Сүүдэр” киного ямар нэг улс төр, үзэл суртлын талаас нь бус цэвэр урлаг, уран сайхан талаас нь тайлж тайлбарласнаараа уг киноны төдийгүй ерөөс монголын уран сайхны киноны түүхэнд

онцлон тэмдэглүүштэй судалгаа болж чаджээ. Энэ дүгнэлтийг тус өгүүллийн “Кино хамгийн сүүлд өөрийгөө буудаж амиа хорлох гэж байсан Дугарыг Сандаг санамсаргүй олж аваад, гэр лүүгээ Дугарыг чирч яваа үзэгдлээр төгсөөж байна. Саяхан төрсөн дүүгээ ч бодсон байх. Тэр үедээ Сандагийн уйлан хамгиран хэлсэн үгэнд анхаарлаа хандуулья.

-Дугар ахаа! Гэртээ харья л даа. Гэртээ харья. Та яаж байна?

Дээрх өгүүлбэрт “гэр” хэмээх үгэнд өгөх-оришихын тийн ялгалын дагавар “-т” залгаж, дараа нь ерөнхийлөн хамаатуулахын “-ээ” дагавар залгасан байна. Өөрөөр хэлбэл, дээрх өгүүлбэрийн тэр “гэр” бол Дугарын “өөрийн нь гэр” гэсэн санааг давхар илэрхийлж буй юм. Ийнхүү Сандаг Дугарыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч нэг гэр бүл болно. Өөрөөр хэлбэл Сандаг Дугарыг “өөрийн гэр” лүүгээ чирч яваа үзэгдэл Дугарыг хар сүүдрээс гэрэл гэгээ рүү, үхлээс амьдрал руу авч явж байгааг уран сайхны аргаар бэлгэдэж байна гэж үзэж болох байх. Бас тус киног бүтээсэн 1986 он бол ардчиллын өмнөх үе байсан боловч, аажмаар өөрчлөлт шинэчлэлт эхэлж байсан үе бөгөөд тус кино Японыг үзэх монголчуудын үзэл нааштай болж эхлэхийг шууд бус аргаар бэлгэдсэн байна гэхэд арай хилсдэхгүй болов уу”(105 дугаар тал) гэсэн дүгнэлтээр давхар баталж болно. Халхын голын дайны тухай сэдэвт киноноос нэлээд өвөрмөц болсон буюу нэгд, киноны дүрийн дотоод сэтгэл зүйг дайны үйл явдалтай уялдуулан нээхийг оролдсон, хоёрт, япончуудыг үзэх монголчуудын үзэл баримтлалд гарсан өөрчлөлтийг сонирхолтой харуулсан “Сүүдэр” киноны тухай шинэлэг судалгаа нь судлаачийг нэг л тодорхой зүйлийг сонгон авч олон талаас нь ултай судлан шинжилж, үнэлэлт дүгнэлтэд хүрдэг онцлогийг харуулж байна.

Дөрөв. Д. Нацагдорж судлал, Ц. Дамдинсүрэн судлал, Монгол, Японы нийгэм, урлаг, уран зохиолын харилцаа холбооноос гадна монголын орчин үеийн уран зохиолын зарим асуудлаар багагүй судалгаа хийснийг Монголын орчин үеийн уран зохиол дахь эсэргүү яруу найрагч Рэнчиний Чойномын судлал, Монголын уран зохиолын үечлэл, түүхэн хөгжил хувьслын тухай бичсэн далайцтай судалгаануудаас харж болно. Тухайлбал, нэгэн цагт эсэргүү яруу найрагч гэж цоллуулан мөрдлөгө хавчлага, шорон гяндангийн амьдралыг дамжсан Рэнчиний Чойномын зарим шүлэг найраг, үзэл бодолд нь дүн шинжилгээ хийж “Өнөө үеийн “өөрчлөлт шинэчлэл”-ийг зарласан Р. Чойномыг цагаатгасан нь монголын орчин үеийн уран зохиолын түүхэнд шинэ эрэлт болох бэлгэ дэмбэрэлтэй үйл явдал бөгөөд монголын утга зохиол урлагийн хүрээнд эрх чөлөөтэй шүүмжлэл, судлал бүрэлдэхэд түлхэц болно гэж бодож байна” (24 дүгээр тал) гэсэн сонирхолтой дүгнэлтэд хүрчээ.

Японы нэрт монголч эрдэмтэн Казүюки Окада профессорын “Алтан хараацай” ном Монголын орчин үеийн уран зохиол судлалын эдрээтэй олон асуудлыг шинжлэх ухаанч байр сууринаас тогтолцоотой судлан шинжилсэн доривтой бүтээл болсон тул түүнийг үе дамжуулан уншиж, судалсаар байх нь эргэлзээгүй. К. Окада эрдэмтний “Алтан хараацай”-н үүрэн дэх алт эрдэнэсийг нээхүйд монголын утга зохиолд элэгтэй хэн бүхэнд ийм сэтгэгдэл, үнэлэлт дүгнэлт төрөх нь дамжиггүй.

Тэнгэрийн цээлд халин дүүлэх Алтан хараацай жаргалтай. Эрдмийн мандлаас сувд тана шүүрдсэний гэрч “Алтан хараацай” монголын судлалд үнэтэй. Алтан хараацайг нисгэх тэнгэрийн уудмийг бишрэлтэй. “Алтан хараацай”-г бичсэн эрдэмтэний гавьяаг магталтай.

НОМЫН ЦАГААН БУЯН ҮЛЭМЖ ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ